



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 225

Улаанбаатар хот

“Жинст-Увс” ХК-д “Хөрөнгө оруулагч үндэстэн” хаалттай ХК-ийг нэгтгэхийг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Жинст-Увс” ХК-ийн нийт гаргасан нэг бүр нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 53,223 /тавин гурван мянга хоёр зуун хорин гурав/ ширхэг хувьцааг тус компанид нэгдэж буй “Хөрөнгө оруулагч үндэстэн” хаалттай ХК-ийн хөрөнгөд ногдох нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,612,715 /нэг сая зургаан зуун арван хоёр мянга долоон зуун арван тав/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн, нийт нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,665,938 /нэг сая зургаан зуун жаран таван мянга есөн зуун гучин найм/ ширхэг хувьцаа болгон нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхийг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т үүрэг болгож, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТХТ” ХХК /Ш.Лхагва/-д зөвшөөрсүгэй.

2. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт орсонтой холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Жинст-Увс” ХК /Т.Батцэнгэл/-д үүрэг болгосугай:

1/ Тогтоол батлагдсантай холбогдуулан компанийн дүрэм, улсын бүртгэлийн гэрчилгээнд зохих өөрчлөлтийг оруулж Оюуны өмч, улсын бүртгэлийн газарт бүртгүүлж, холбогдох баримт бичгийг ажлын 20 хоногт багтаан Санхүүгийн зохицуулах хороонд ирүүлэх;

2/ “Жинст-Увс” ХК-д “Хөрөнгө оруулагч үндэстэн” хаалттай ХК-ийг нэгтгэх асуудлыг шийдвэрлэсэн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй эсхүл эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг Компанийн тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлэх;

3/ 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тэнцэлд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд орсон өөрчлөлтийг тусгах;

4/ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 443 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам"-д заасан мэдээллийг тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

5/ Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан "Компанийн засаглалын кодексе"-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц /-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН